



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/610

Улаанбаатар хот

Тээврийн хэрэгсэл бүртгэн
авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.6 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 78 дугаар зүйлийн 2 дугаар хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 3.2.2-т заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан нийт 363,300,000.00 (гурван зуун жаран гурван сая гурван зуун мянга) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан тээврийн хэрэгслийг нийслэлийн өмчид бүртгэн авсугай.

2. Тээврийн хэрэгслийг бүртгэн авч, ашиглалт хамгаалалтыг хариуцан ажиллахыг Багануур дүүргийн Онцгой байдлын хэлтэс (Г.Батжаргал), Налайх дүүргийн Онцгой байдлын хэлтэс (Л.Чинбат), Багахангай дүүргийн Эрүүл мэндийн төв (Х.Ганбат)-д тус, тус үүрэг болгосугай.

3. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-г даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110202957



Нийслэлийн Засаг даргын 2024 оны
05 дугаар сарын 28 өдрийн
41670 дугаар захирамжийн
хавсралт

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭН АВАХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ

Д/д	Хөрөнгийн нэр	Марк	Арлын дугаар	Улсын дугаар	Үйлдвэрлэсэн он	Бүртгэх үнэ /төгрөгөөр/	Эх үүсвэр	Эзэмшигч байгууллагын нэр
1	Туулах чадвар сайтай автомашин	Тоёото, Ландкриузер-Ј76	ЈТЕЕВ71ЈХ0F024394	УЕК 12-76	2023	152,000,000.0	Улсын төсөв	Багануур дүүргийн Онцгой байдлын хэлтэс
2	Туулах чадвар сайтай автомашин	Тоёото, Ландкриузер-Ј76	ЈТЕЕВ71Ј50F024366	УБИ 02-76	2023	152,000,000.00	Улсын төсөв	Налайх дүүргийн Онцгой байдлын хэлтэс
3	Дунд оврын автомашин	Митцубиши Делика	CV5W0902006	УЕМ02-52	2013	59,300,000.00	Нийслэлийн төсөв	Багахангай дүүргийн Эрүүл мэндийн төв
Нийт дүн						363,300,000.00		

1110202056